



ЗАХИРГААНЫ АЛБАДАН ГАРГАХ БУЮУ ХУУЛИЙН ДАГУУ ЧЕХ УЛСАД ОРШИН СУУХ БОЛОМЖ



Танд хуулийн дагуу энэхүү нутаг дэвсгэрээс албадан гаргах захиргааны арга хэмжээ авсан бол таний хувьд буцаж ирэх боломжтой юу?

АЛБАДАН ГАРГАХ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Захиргааны албадан гаргах гэдэг нь гадаадын иргэнийг Чех улсын газар нутагт оршин суухыг хориглосон ба Чех улсын нутгаас гарч явсаны дараа дахиад давтан ирэхийг хориглоно. Гадаадын иргэдийг хариуцсан цагдаагийн газрын шийдвэрийн дагуу гадаадын иргэн хэд хоногийн дотор Чех улсын нутгаас гарч явах хугацаа болон дараа нь хэр удаан хугацааны дараа дахиж ирж болох хугацааг нарийвчлан заасан байна. Албадан гаргах нь эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн гэмт хэрэг биш боловч оршин суух журмыг зөрчихөөс сэргийлсэн арга хэмжээ юм.

Захиргааны албадан гаргах нь Чех улсын нутагт гадаадын иргэн оршин суух тухай хуулийн 326|1999 тоотод тусгагдсан бөгөөд цагдаагийн газраас ямар шалтгааны улмаас албадан гаргахыг, нөгөө талаас хэдийд албадан гаргаж болохгүй тухай заасан байна. Чех улсын нутагт амьдрахыг хориглосон хугацаа нь хүндэтгэх шалтгааны улмаас хамаарч урт богино янз бүр, хамгийн дээд хугацаа нь 3,5 мөн 10 жил ч байж болно

АЛБАДАН ГАРГАХЫН ҮР ДҮН

- албадан гаргах нь Чех улсын нутгаас гарч явах үүргийг баримтална
- Чех улсын болон Исланд, Норвег, Цвецар, Европийн холбооны орнуудын Шингений мэдээллийн төвд зөвшөөрөгдөөгүй хүний тоонд бүртгэгдэнэ
- шинээр Чех улс болон Шингений орнуудад нэвтрэх виз олгохгүй

Хэрэв тогтоосон хугацаанд Чех улсын гарч явахгүй бол танийг цагдаагийн газрын шийдвэрийг үндэслэн гадаадын иргэдийг түр хорих байранд байлгаж байгаад хүчээр албадан гаргах болно. Бас “албан шаардлагыг үл тоомсорлосон” гэж үзээд энэ нь гэмт хэргийн нэг хэлбэр болох ба дараа нь таний Чех улс руу ирэх боломжийг хүндрүүлнэ.

ЭХ НУТАГТ НЬ БУЦААХ АСУУДЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭЛБЭРҮҮД

1. Сайн дураараа. Энэ нь шийдвэр гарсаны дараа сайн дураараа Чех улсын нутгаас гарч явах
2. Сайн дураараа Олон улсын Цагаачлалын Байгууллагын төлөөлөгчтэй хамтарч, энэ нь та хил нэвтрэх бичиг баримтгүй тохиолдолд албадан гаргах шийдвэр гарсаны дараа \ Гадаадын иргэдийн оршин суух тухай хуулийн 123а-д зааснаар\ буцах тухай Дотоод Явдлын Яамнаас тусламж хүсэж болно.
3. Албадан гаргах, энэ нь та та сайн дураараа гарч яваагүй байвал гадаадын иргэд хариуцсан цагдаагийн газар энэ үйл ажиллагааг гардаж хийх ба танийг явах газар тань хүргээд бичиг баримт болон өөрийг тань явах унааны даргад тушааж өгөөд нутагтаа очсон хойно нь бичиг баримтийг тань өгнө.
4. Харгалзагчтай албадан гаргах гэдэг нь та энэ үйл ажиллагааны эсрэг байвал цагдаагийн харгалзагч эх нутагт тань аваачаад зохих байгууллагад нь өгнө.
5. Иргэдийг эх нутагт нь хүлээлгэж өгөх олон улсын гэрээг үндэслэн буцаана

ЧЕХ УЛС РУУ ЭРГЭЖ ИРЭХ БОЛОМЖУУД

Хэрвээ доор дурдсан шаардлагууд биелэгдсэн бол:

- албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэн Чех улсаас явах
- албадан гаргахад бүх зардлаа өөрөө төлөх\ 123а-д зааснаар сайн дураар буцах төсөлд хамрагдаад ядаж зардлынхаа хагасыг өөрөө төлсөн бол\
- Чех улсын нутагт амьдрахыг хориглосон хугацааны хагас нь өнгөрөөд албадан гаргасан шалтгаан өршөөгдсөн бол эх нутгаасаа цагдаагийн газарт албадан гаргах шийдвэрийг хүчингүй болгох тухай өргөдөл өгч болно.
- Хориглосон хугацааны дараа зөвшөөрөгдөөгүй хүмүүсийн бүртгэлээс хасагдсан тохиолдолд Чех улсад хууль ёсоор орж ирэхэд ямар ч саадгүй болно.





ЗАХИРГААНЫ АЛБАДАН ГАРГАХ АСУУДАЛТАЙ ХАМААРАГДАХ ЭРХҮҮД

- Үйл ажиллагаа эхэлсэн тухай мэдээлэл авсан байх эрхтэй
- Үйл ажиллагаанд орчуулагчтай байх эрхтэй
- Албадан гаргах тухай үйл ажиллагаанд төлөөлүүлэх эрхтэй
- Бичиг баримттайгаа танилцах болон баримт нотолгоо хэлэх эрхтэй
- Гарсан шийдвэртэй холбоотой саналаа илэрхийлэх эрхтэй
- Үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээний эсрэг санал гомдлоо илэрхийлэх эрхтэй
- 5 хоногийн дотор давж заалдах эрхтэй |хэрвээ давж заалдах хугацаа дууссан тохиолдолд буюу давж заалдсаныг хүчингүй болгосныг судлах эрхтэй

АЛБАДАН ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИЙН ҮҮРЭГ

- Захиргааны байгууллагаас зарлан дуудахад ирэх болон үйл ажиллагааны явцыг хүндрүүлэхгүй байх
- Өөрийн мэдүүлэгтээ нэмэр болгон нотолгоо баримт үзүүлэх ба мэдүүлэгт өгсөн дутуу зүйлээ тэмдэглүүлэх
- Батлан даалтын бичиг баримтад үнэн зөв мэдээлэл өгөх
- Үйл ажиллагааны зардлыг хуулиар тогтоосон хэжээний дагуу \ 1000,-к\ төлөх
- Хуулиар батлагдсан хугацааг баримталж цагт нь явах

АЛБАДАН ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ДАРААЧИЙН АСУУЛТУУД

Албадан гаргах ба сайн дураараа нутаг буцах тухай илүү ихийг мэдэхийг хүсэж байна уу?

Хэрэв та Чех улсад гэр бүлтэй бол албадан гаргах үйл ажиллагаанд яаж нөлөөлхийг мэдэхийг хүсэж байна уу?

Ямар аргаар албадан гаргахыг хүчингүй болгохийг мэдмээр байна уу?

Та шашин шүтлэг, арьс өнгө, улс төрийн эсвэл нийгмийн салбарт хамаатай шалтгаанаас болж эх нутагтаа очихоос эмээж байна уу?

Эдгээр сайн дураараа нутаг буцах ба албадан гаргахтай холбоотой асуултуудад таньд үнэгүй гадаадын иргэдэд тусладаг төрийн бус байгууллагын хуулийн зөвлөгч нархариулж өгнө. Бас адилхан таны албадан гаргах үйл ажиллагааны явцад таньд зөвлөх ба даван заалдах асуудалд туслана.


Тусламж хүсэж хэнд хандаж болох

SOZE – Цагаачдын асуудлыг хариуцсан иргэдийн нэгдэл
Mostecká 5
614 00 Brno
Tel: 545 213 643
Fax: 515 536 356
e-mail: soze@soze.cz
www.soze.cz

Цагаачдад туслах байгууллага - **OPU**
Kovářská 4
190 00, Praha 9
Tel: 284 683 545
Fax: 233 371 258
e-mail: opu@opu.cz
www.opu.cz

Чех улсын дотоод явдлын яам
цагаачлал болон шилжин суурьших бодлого хариуцсан салбар
P.O.Box 21/OAM,
170 34 Praha
Tel: 974 832 495, 974 832 502
e-mail (OAMP): opu@mvcr.cz
www.mvcr.cz

Олон улсын шилжин суурьших бодлого хариуцсан байгууллага (**IOM**)
Čechova 23
170 00 Praha 7
Tel: 233 370 160, 233 376792
Fax: 233 382 259
e-mail: prague@iom.int
www.iom.cz



SOZE Гэрлүүгээ буцах төсөлд Европын буцаах фонд хамтран хөрөнгө оруулсан

